



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 1/09

Улаанбаатар хот

Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах,
үзэсгэлэн арга хэмжээнд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 122 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/341 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 4.1.9, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард улсын Гуанжоу, Хонгконг, Бээжин хотуудад 2024 оны 04 дүгээр сарын 23-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Роад шоу", Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотод 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Сөүлийн олон улсын аялал жуулчлалын экспо" арга хэмжээнд оролцож Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсугай.

2. "Сөүлийн олон улсын аялал жуулчлалын экспо" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 116,194,000 (нэг зуун арван зургаан сая нэг зуун ерэн дөрвөн мянга) төгрөг, 2560 (хоёр мянга таван зуун жар) ам.долларыг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-г даалгасугай.


ДАРГА



Д.БАТСҮХ

F:\NAJG 2024\A Тушаалын төсөл\2024.04.15 A09.docx

1150500055



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2024 оны 04 сарын 02 өдрийн А/О дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“СӨҮЛИЙН ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭКСПО” АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2024 оны 04 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

- Дарга - Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Туул
- Гишүүд - Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн ажлын албаны дарга М.Нарангэрэл
- Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн ажлын албаны дэд дарга Ц.Түвшинжаргал
- Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбооны тэргүүн Ч.Батхуяг
- Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбооны гишүүн Д.Үнэнбаат
- Нарийн бичиг - Нийслэлийн Аялал жуулчлалын газар Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Д.Сайханчимэг

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2024 оны сарын өдрийн
109 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



УЛААНБААТАР ХОТЫГ ОЛОН УЛСАД СУРТАЛЧЛАХ ҮЗЭСГЭЛЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

2024 оны дүгээр сарын

Улаанбаатар хот

1. БНХАУ "Роад шоу" аялал жуулчлалын үзэсгэлэн арга хэмжээ					
№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	150 м ²	330,000 төгрөг	40,000,000 төгрөг	
2	Нислэгийн тийз УБ – Бээжин Бээжин - УБ	7 хүн	690,000 төгрөг	4,830,000 төгрөг	
3	Нислэг /Хятад/ Бээжин - Гонжоу Гал тэрэг Гуонжоу- Хонгконг Хонгконг - Бээжин	7 хүн	1,322,000 төгрөг	9,254,000 төгрөг	
4	Урлагийн багийн байрлах зардал Хонгконг /1 хоног/ Гуонжоу /3 хоног/ Бээжин /3 хоног/	6 хүн* 7 хоног	230,000 200,000 220,000 төгрөг	8,940,000 төгрөг	
5	Урлагийн багийн хоол унааны зардал	6 хүн* 7 хоног	167,285 төгрөг	7,026,000	
Нийт				70,050,000	
Албан томилолт					
№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр
1	Байрлах зардал	1хүн* 7хоног	110 ам.доллар	660 ам.доллар	Бэлнээр
2	Зам хоног/унаа	1хүн* 7хоног	50 ам.доллар	300 ам.доллар	Бэлнээр
Нийт: 70,050,000 төгрөг, 960 ам.доллар					
2. БНСУ "Сөүлийн олон улсын аялал жуулчлалын экспо" арга хэмжээ.					
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	36 м ²	694,000 төгрөг	25,000,000 төгрөг	
2	Нислэгийн тийз /УБ-Сөүл-УБ/	7 хүн	1,300,000 төгрөг	9,100,000 төгрөг	
3	Урлагийн багийн буудлын зардал	5 хүн* 4өдөр* Зөрөө	450,000 төгрөг	5,400,000 төгрөг	

4	Урлагийн унаа, зардал	багийн хоолны	5 хүн* 4өдөр	204,000 төгрөг	4,080,000 төгрөг
5	Хөгжим, зөөх түрээс	сэтгүүл унааны	1 жижиг автобус * 2 өдөр	1.021.000 төгрөг	2.042.000 төгрөг
6	Визний материал орчуулга	хураамж;	6 хүн	87,000 төгрөг	522,000 төгрөг
Албан томилолт					
№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр
1	Буудал	2хүн* 4хоног	150 ам.доллар	1200 ам.доллар	Бэлнээр
2	Зам хоног/унаа	2хүн* 4хоног	50 ам.доллар	400 ам.доллар	Бэлнээр
Нийт: 46,144,000 төгрөг, 1600 ам.доллар Гадаад валютыг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.					
Нийт дүн				116,194,000 2560 ам.доллар	